

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР
 “ШИНЭ СЭРГЭЛТИЙН БОДЛОГО”-ЫГ ХЭРЭГЖҮҮЛЭХ
 ЭХНИЙ ҮЕ ШАТНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨРИЙН ХЭРЭГЖИЛТ
 /Жилийн эцэс/

2022 оны 12 дугаар сарын 06-ны өдөр

Улаанбаатар хот

Д/д	Шинэ сэргэлтийн бодлогод тусгагдсан үйл ажиллагаа	Зорилт, үйл ажиллагаа	Эхлэх хугацаа	Дуусах хугацаа	Хийгдсэн ажлууд	Өмнөх долоо хоногийн хэрэгжилт ийн хувь	Энэ долоо хоногийн хэрэгжилт ийн хувь	Хүлээгдэж буй ажлууд	Зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхэд тулгамдаж буй асуудал	Хариуцах байгууллага
0		1	2	3	4	5	6	7	8	9
4.2.2.	Шинэ суурьшлын бүс, эдийн засгийн чөлөөт бүс, дагуул хотын бүтээн байгуулалтыг эрчимжүүлэх	Налайх барилгын материалын үйлдвэр технологийн парк байгуулна.	2022	2024	<ul style="list-style-type: none"> НБМҮТП-ийн үндсэн цахилгаан хангамжийн бүтээн байгуулалтад 2022 онд нийслэлийн төсвөөс 3,577.3 сая төгрөг тусгагдсан бөгөөд төсвийн тодотголоор 1,000,0 сая төгрөг нь хасагдсан. Үндсэн цахилгаан хангамжийн ажлыг гүйцэтгэгч “Вилл вест” ХХК нь “110/10 кВ-ын дэд станцын ил хуваарилах байгууламжийн өргөтгөл”-ийн тоног төхөөрмжийн суурь, “10 кВ-ын кабель шугамын угсралт”-ын ажлыг бүрэн дуусгасан. “10 кВ-ын хуваарилах байгууламж”-ийн тоноглолын угсралт, суурилуулалтын ажил болон 1,000.0 сая төгрөгийн тоног төхөөрөмж, материалын захиалга хийн татан авалтын ажлуудыг хийж байна. 1000 м3 цэвэрлэх байгууламжийн хөрөнгө оруулалтыг “Европын сэргээн босголт, хөгжлийн банк”-ий санхүүжилтээр гүйцэтгүүлэх санал хүргүүлээд байна. Нийт төсөвт өртөг 4.403.220.000 төгрөг. 26 МВт-ийн дулааны станцын хөрөнгө оруулалтыг барилга хот байгуулалтын яамны 2023 оны төсвөөр гүйцэтгүүлэхээр санал хүргүүлээд байна. Нийт төсөвт өртөг 10.486.502.000 төгрөг. ҮТП-ийн дэд бүтцийн ажлуудын гадна цахилгаан хангамжийн ажлын зураг төслүүдийн хөрөнгө оруулалтыг шийдвэрлүүлэхээр НЗДТГ, БХБЯ болон холбогдох газруудад хүсэлт гаргасан. 2022 онд парктэй гэрээ байгуулсан 2 аж ахуйн нэгж бичиг баримтын бүрдэл хангагдан үйлдвэрийн бүтээн байгуулалтын ажлаа эхлүүлсэн бөгөөд Налайх дүүргээс 18 иргэнийг түр ажлын байраар ханган, барилга угсралтын ажил 30%-тай явагдаж байна. “Таван толгой түлш” ХХК-ийн зүүн бүсийн үйлдвэрийг усаар хангах усан хангамжийн байгууламж, усан сан, гүний худгийн барилга байгууламж, шугам хоолойн угсралтын ажлын бүтээн байгуулалтыг эхлүүлэх ажлын хүрээнд паркийн 120 га газар дээр байгуулах 2 ширхэг гүний худгийн өрөмдлөгийн ажил хийгдэж дууссан. 2 худгийн барилгын ажил хийгдэж байна. “ТТТ” ХХК-руу татах 6.3 км шугам хоолойн газар шорооны ажил хийгдэж байна. Барилга хот байгуулалтын сайдын 2020.09.07-ны өдрийн 169 дугаар тушаалын дагуу паркийн өргөтөл 130 га газрын хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөг боловсруулах зөвлөх үйлчилгээний сонгон шалгаруулалт явагдаж 228.8 сая төгрөгөөр “Өрх” ХХК 2021.01.28-ны өдөр 2021/47 дугаар гэрээ байгуулан ажиллаж гүйцэтгэл дууссан ба мэргэжлийн зөвлөлийн дүгнэлт болон магадлал хийлгэх ажлууд хийгдэж байна. 	23%	30%	Паркийн үндсэн цахилгаан хангамжийн төслийг дуусгаж байнгын ашиглалтад оруулахад шаардагдах 8,944,0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтыг шийдвэрлэх шаардлагатай байна.	Цахилгаан хангамжийн санхүүжилт шаардлагатай байна. Паркийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл сунгуулах	НЗДТГ